



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

### XXIX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 11:00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 76 хувийн ирцтэй хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын шинэ хувилбар /В.1.1.529/, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар

*Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд*

2. Дэлхийн улс орнууд коронавируст халдвар /Ковид-19/-ын шинэ хувилбар /В.1.1.529/-ын эсрэг авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний талаар

*Гадаад харилцааны яамны  
Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр,*

3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын шинэ хувилбар /В.1.1.529/-ын талаарх нэмэлт мэдээлэл

*Улсын онцгой комиссын дэргэдэх  
Эрдэмтдийн зөвлөлийн нарийн бичгийн дарга О.Батбаяр,*

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:*

1.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан шинэ хувилбарын тархалтаас сэргийлэх, халдварын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор дархлаа сэргээх нэмэлт тунд хамруулах ажлыг бүх шатанд идэвхижүүлэх;

*Хоёр. Гадаад харилцааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал, Улсын онцгой комиссын гишүүн Х.Лхагвасүрэн, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт:*

2.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан хувилбарын тархалтаас сэргийлэх зорилгоор шинэ хувилбар /В.1.1.529/ бүртгэгдсэн улс орнууд болон тус улсуудаар сүүлийн 14 хоногт зорчсон, дамжин өнгөрсөн гадаад улсын иргэдийг хүлээн авахыг түр зогсоож, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан шинэ хувилбар /В.1.1.529/ бүртгэгдсэн улс орнуудаар сүүлийн 14 хоногт зорчсон, дамжин өнгөрсөн өөрийн улсын иргэдийг эх орондоо ирэх үед нь тусгаарлан ажиглах байранд өөрийнх нь зардлаар 10 хоног тусгаарлаж, шинжилгээ авах ажлыг зохион байгуулах;

2.3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан шинэ хувилбар /В.1.1.529/-ын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн хяналт шалгалтыг эрчимжүүлэх;

*Гурав. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Болд, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт:*

3.1. Гадаад улсаас ирсэн хүнийг байрлуулах тусгаарлан ажиглах байрыг нэн даруй бэлтгэх, тусгаарлан ажиглах, шинжилгээ авах ажлыг зохион байгуулах, уг үйл ажиллагаанд шаардлагатай түр журмыг батлуулж, хэрэгжүүлэх;

3.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн чанадаас ирж буй зорчигчдоос нисэх буудалд болон авто замын хилийн боомтуудад шинжилгээ авч нэвтрүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллах;

*Дөрөв. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан нарт:*

4.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан шинэ хувилбар /В.1.1.529/-ын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх;

шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн орны нөөцөд тодотгол хийж, нөөцийг нэн даруй бүрдүүлэх, Улсын онцгой комисс, Засгийн газрыг үнэн бодит мэдээ, мэдээллээр хангаж, шуурхай ажиллах;

4.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан шинэ хувилбар /В.1.1.529/ бүртгэгдсэн улс орнуудын жагсаалтыг тухай бүр шинэчилж, холбогдох байгууллагуудыг мэдээ, мэдээллээр хангах;

*Тав. Гадаад харилцааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг, Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Зам тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар, Хилийн боомтын Онцгой бүрэн эрхт захиргааны дарга, хошууч генерал Ш.Лхачинжав, Дорноговь аймаг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Онцгой комисст:*

5.1. Замын-Үүд-Эрээн автозамын боомтоор чингэлэг тээврийг эхлүүлэх бэлтгэл ажлыг бүх шатанд хангах, уг ажилтай холбоотой салбар хоорондын уялдааг сайжруулж, чингэлэг тээвэр эхлүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын болон хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх;

*Зургаа. Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Ганзул, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан нарт:*

6.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийг онцын шаардлагагүй тохиолдолд гадаад улс орнууд руу зорчихгүй байх зөвлөмж гаргаж, боломжит бүхий л сувгаар мэдээллийг түгээх;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

